



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 06
сарын 15 өдөр

Дугаар ЗГ-1/124

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Улсын Их Хурлаас 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр баталсан Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд




У.ХҮРЭЛСҮХ

007121



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2016.06.08 № 1-1/2893
танай 2016.06.04 -ны № 01/2570 -т

┌ **ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД** ┐
└ **Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА** ┘

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр баталсан Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Ц.НЯМДОРЖ

08.2018
Даргач




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С. Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.06.11 № 6/3680
танай 2018.0604 ны № 01/2570-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дотоод хэрэгцээнд 1998-2015 онд импортолсон дизелийн түлшний онцгой албан татварт төлсөн 73,8 тэрбум төгрөгийг “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-аас авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох тухай Улсын Их хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР


0 976

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлд:

"ХҮИИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 06 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар ... 1334

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ЦОЛМОН ТАНАА

Тов тогтоолгох тухай

Улсын Их Хурлаас 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр баталсан Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.



Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 Г.ЗАНДАНШАТАР

005041



**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол-Зөвлөлтийн Хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийн наймдугаар зүйлийн “ж” дэх заалтыг үл харгалзан Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг 1998-2015 онд өөрийн хэрэгцээнд импортлосон дизелийн түлшинд ногдох онцгой албан татварыг төлсөөр ирсэн байна.

Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасан. Түүнчлэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн 1998-2015 онд төсөвт төлсөн онцгой албан татварын орлогыг жил бүр улсын төсвийн орлогын гүйцэтгэлд бүртгэдэг бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн баталсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн өөрийн хэрэгцээнд импортоор оруулах дизелийн түлшийг 1998 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн онцгой албан татвараас чөлөөлөх шаардлагатай гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.23 дахь заалтад заасны дагуу онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь тус хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлалд хамаарахгүй тул хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, үр нөлөөг үнэлэх болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх шаардлагагүй болно.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд 1 дэх зүйлд Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн өөрийн хэрэгцээнд импортоор оруулах дизелийн түлшийг 1998 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн онцгой албан татвараас чөлөөлөхөөр, 2 дахь зүйлд энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгана.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, зээлийн эргэн төлөлтийг бууруулах, үндсэн үйл ажиллагааг дэмжих болно.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулж. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дотоод хэрэгцээнд зориулж 1998-2015 онд импортолсон дизелийн түлшний онцгой албан татварт төлсөн 73.8 тэрбум төгрөгийг тус нийгэмлэгийн илүү төлсөн төлөлтөд бүртгэж, “Японы Олон улсын хамтын ажиллагааны банк”-наас авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох асуудлыг шийдвэрлэх Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулна.

ТАНИЛЦУУЛГА

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” хэлэлцээрийн наймдугаар зүйлийн “ж”-д заасны дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн өөрийн хэрэгцээнд импортлон оруулж байсан технологийн зориулалттай дизелийн түлшинд 1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд тухайн үед хэрэгжиж байсан худалдааны албан татварыг ногдуулдаггүй байсан.

Харин 1998 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль үйлчилж Худалдааны татварын тухай хууль хүчингүй болсноор Гаалийн ерөнхий газрын харъяа Улаанбаатар хотын Гаалийн газраас нефтийн бүтээгдэхүүнд нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийг нэхэмжлэснийг “Улаанбаатар төмөр зам” ХНН 1998 оны 7 дугаар сарын 1-ээс 9 дүгээр сарын 30-ны өдрийн хугацаанд 135.5 сая төгрөгийг улсын төсөвт төлж байжээ.

Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газрын хамтарсан 1998 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хурлаар тус нийгэмлэгийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэхгүй байх тухай шийдвэрийг гаргаж байв.

Тухайн үеийн “УБТЗ” ХНН-ийн удирдлагууд 1998 оны 7 дугаар сарын 1-ээс 9 дүгээр сарын 30-ны өдрийн хугацаанд төлсөн НӨАТ-ыг Гаалийн ерөнхий газрын нэхэмжилж байсан 167.0 сая төгрөгийн дизель түлшний онцгой албан татварт суутган тооцох хүсэлтийг гаргасан үеэс эхлэн тус нийгэмлэг өөрийн хэрэгцээнд импортлон оруулж байсан технологийн зориулалттай дизелийн түлш, автобензинд албан татвар болон онцгой албан татварыг улсын төсөвт төвлөрүүлдэг болж, 1998-2015 оны хооронд зөвхөн дизель түлшний онцгой албан татварт 73.8 тэрбум төгрөг төлсөн байна.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай 1949 оны хэлэлцээрт төмөр замын барилга ба ашиглалтыг хангахын тулд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь доор дурдсан үүргийг хүлээхээр заасан байдаг:

“Төмөр замын хайгуул шинжилгээ ба барилга болон ашиглалтад чухал хэрэглэгдэх төхөөрөмж, материалуудыг шалган үзэх ба гааль, татвар хураахгүйгээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсад нэвтрүүлэн оруулж байх, түүнчлэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсад оруулсан хогшил хөрөнгийг СССР улсад саадгүй эгүүлэн гаргахыг зөвшөөрнө. Замын хайгуул шинжилгээ ба барилгыг явуулж буй үед мөнхүү барилгын ажилчин, албан хаагчдад хэрэглүүлэх хүнсний болон аж үйлдвэрийн хийгээд бусад бараа товарыг гааль, татвар хураахгүйгээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсад нэвтрүүлэн оруулж байхыг зөвшөөрнө”.

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн өөрийн хэрэгцээнд импортлох дизелийн түлшинд ногдуулдаг онцгой албан татварыг чөлөөлүүлэх, 1949 онд байгуулсан хэлэлцээрийг дагаж мөрдөх хүсэлтийг тус нийгэмлэг болон ОХУ-ын талаас удаа дараа тавьсан бөгөөд Улсын Их Хурал 2016 онд Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталснаар 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийг онгой албан татвараас чөлөөлсөн.

Япон Улсын Засгийн газраас авсан иений хөнгөлөлттэй зээлийн зарим хэсгийг 17.892.038.771 иен/ "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн техникийн шинэчлэлийн хүрээнд авч Сангийн яам, "УБТЗ" ХНН-ийн хооронд төсөвт эргэн төлөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх "МОН-П1", "МОН-П2" зээлийн гэрээг 2000 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан.

"Улаанбаатар төмөр зам" ХНН нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлснээс 2017 оны жилийн эцсийн байдлаар 3.7 тэрбум иенийн зээл, хүүгийн төлбөрийн төлөх хугацааг хэтрүүлж, зээлийн гэрээнд үндсэн зээл, хүүгийн хугацаа хэтрүүлсэн төлбөрийн дүнгээс жилийн 8.0 хувийн алданги тооцохоор заасны дагуу 2018 оны 2 дугаар сарын 19-ний байдлаар "МОН-П1"-ийн хувьд 607.702.362.01 иен, "МОН-П2"-ийн хувьд 793.434.834.10 иенийн төлбөрийг төлөхөөр болсон.

2007 он хүртэл зээлийн үндсэн өр, түүний хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу төлж ирсэн бөгөөд эдийн засгийн хямралаас үүдэн "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн тээвэрт ашиглагдаж буй үйлдвэрлэлийн гол түүхий эд болох нефть бүтээгдэхүүн, сэлбэг материалын үнэ дэлхийн зах зээл дээр огцом өсч, тэдгээрийг худалдан авч буй гадаад валютын ханш нэмэгдсэн зэрэг нь тээврийн үндсэн үйл ажиллагааны зардлыг өсгөж, тухайн үед тээврийн орлогын 50 орчим хувийг бүрдүүлж, орон нутгийн зорчигч болон ачаа тээврийн алдагдлыг 100 хувь хааж байсан дамжин өнгөрөх тээврийн тоо хэмжээг жилээс жилд бууруулснаар тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого багасч, улмаар 2007 онд 29.8, 2009 онд 6.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, зээлийн үндсэн өр, түүний хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу төлөх санхүүгийн чадваргүй болсон юм.

Улаанбаатар төмөр зам нь нийгмийн чанартай, өндөр алдагдал бүхий зорчигч болон дулааны цахилгааны станцуудын хэрэглээний нүүрсний тээврийг гүйцэтгэхээс гадна 3 дугаар шатлалын эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, шугам зам дагуух хүүхдийн 26 цэцэрлэг, төвлөрсөн шугамд холбогдоогүй шугам замын хэсгүүдийн орон сууц, нийгэм хангамжийн аж ахуй, сурагчдын дотуур байр, хүүхдийн зуслан, дуу бүжгийн чуулга, "Баянбуурал амралт", Тээврийн дээд сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв зэрэг нийгмийн чиглэлийн салбар нэгжүүдийг улсаас татаас авалгүй санхүүжүүлж байна.

Дулааны цахилгаан станцууд (ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4, ДДЦС, ЭДЦС, Амгалан-ДС)-ыг эрчим хүчний нүүрсээр хангах, тээвэрлэлтийг жигд, тасралтгүй зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллаж ирснээс гадна энэхүү тээврийн тариф нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, ард түмний амьжиргааны түвшинд шууд нөлөөлдөгтэй холбоотойгоор тээврийн тарифыг тодорхой түвшинд барьж, алдагдлыг өөр дээрээ хүлээж ирсэн зэрэг нь тус нийгэмлэгээс дээр дурдсан зээлийг төлөхөд хүндрэл учруулж байгаа юм.

"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр зохицуулагддаг.

Тус хэлэлцээрийн дагуу Монгол Улс "Улаанбаатар төмөр зам"-ын ашиглалтад чухал шаардлагатай бараа материалыг гаалийн татвар, хураамжгүй оруулах Олон улсын гэрээ, хэлэлцээрээ мөрдөж "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн дотоод хэрэгцээнд импортоор оруулах дизелийн түлшийг онгой албан татвараас чөлөөлж, 1998-2015 онд импортолсон дизелийн түлшний онцгой албан татварт төлсөн 73.8

тэрбум төгрөгийг “Олон улсын хамтын ажиллагааны Японы банк”-аас авсан “МОН-П1”, “МОН-П2” хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох арга хэмжээ авахгүй бол тус нийгэмлэгийн тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогсох хүртэл эрсдэл үүсч болзошгүй байна.

Иймд хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зөрчиж, төмөр замын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд гол хэрэгцээтэй материал болох дизелийн түлшинд 1998-2015 оны хооронд ногдуулж ирсэн онцгой албан татварыг чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Иймд хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр батлагдсан Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1 дүгээр зүйл. Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн өөрийн хэрэгцээнд импортоор оруулах дизелийн түлшийг 1998 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн онцгой албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн талаар
авах арга хэмжээний тухай

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” хэлэлцээрийн наймдугаар зүйлийн “ж”, Татварын ерөнхий хуулийн 2.2, Өрийн удирдлагын тухай хуулийн 32.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1.1. Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн дотоод хэрэгцээнд 1998-2015 онд импортолсон дизель түлшний онцгой албан татварт төлсөн 73.8 /далан гурван тэрбум найман зуун сая/ тэрбум төгрөгийг тус нийгэмлэгийн илүү төлсөн татвараар бүртгэх;

1.2. Энэ тогтоолын 1.1-д заасан 73.8 тэрбум төгрөгийг “Олон улсын хамтын ажиллагааны Японы банк”-наас төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулж олгосон “МОН-П1”, “МОН-П2” хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу тооцсон алданги, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс суутган тооцох.

2. Энэхүү тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхэд оролцох ажлын хэсэг

1. Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ,
2. Сангийн дэд сайд Х.Булгантуяа,
3. Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл,
4. Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Р.Мэргэн,
5. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг,
6. Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал С.Ганхуяг,
7. Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артур,
8. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Алтанзул,
9. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Сүх-Очир,
10. Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Лхагвасүрэн,
11. Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Хулан,
12. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын дарга Д.Жигжиднямаа,
13. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны орлогч дарга Б.Ариунаа.